



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/82

Даланзадгад

Өмнөговь аймгийн эхээс хүүхдэд ХДХВ, гепатит В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихаас сэргийлэх бүсчилсэн сургалт болон ХДХВ/БЗДХ-ын тусламж үйлчилгээний байдалд дэмжлэгт хяналт хийх ажлыг зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Эхээс хүүхдэд ХДХВ, гепатит В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох журам" А/614 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллага, нарийн мэргэжлийн эмч нарт "Эхээс хүүхдэд ХДХВ, гепатит В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох" арга хэмжээний модулийн дагуу бүсчилсэн сургалтыг зохион байгуулсугай

2. Өмнөговь аймгийн БЗДХ, ХДХВ болон вируст гепатитын тусламж үйлчилгээ болон эхээс хүүхдэд эдгээр гурван халдвар дамжихаас сэргийлэх үйл ажиллагаа, БЗДХ-ыг илрүүлэх лабораторийн чадавх, эрүүл мэндийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсугай

3. Арга хэмжээний зардалд 30 593 550 (гучин сая таван зуун ерэн гурван мянга таван зуун тавь) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн төсөл хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтын арга хэмжээг цар тахлын үеийн халдвар хамгаалал, холбогдох дүрэм журмыг баримтлан зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өргөн хүрээнд хамруулан үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн (Б.Амгалан)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Мидэрсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ШИЖИРТУЯА

